

**"МОНГОЛЫН ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧДЫН ХОЛБОО"**

**ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ДҮРЭМ**

**Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

9072 00 6058

2023 05 03

НЭМБ

- 1.1. Энэхүү дүрмээр "Монголын Даатгалын Зуучлагчдын Холбоо" /цаашид "Холбоо" гэх/-ны зорилго, чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэл, удирдлага, бүтэц зохион байгуулалт, гишүүнчлэл болон түүнтэй холбогдон үүссэн бусад харилцааг зохицуулна.
- 1.2. Холбоо нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхэлж буй даатгалын зуучлагч байгууллагууд /цаашид "Гишүүд" гэх/-ыг сайн дурын үндсэн дээр нэгтгэсэн, төрөөс хараат бус, бие даасан, ашгийн бус, гишүүдтээ үйлчилдэг төрийн бус байгууллага мөн.
- 1.3. Холбоо нь Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль, Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль болон тэдгээрт нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжийн акт болон энэхүү дүрмийн шаардлагад нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулна.
- 1.4. Холбооны зорилго нь гишүүд болон даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах, даатгалын зуучлагчийн салбарын өмнө тулгарсан бодлогын шинж чанартай асуудалд нийт Гишүүдийн үйл ажиллагааг нэгтгэн чиглүүлэх, тэдэнд мэргэжлийн туслалцааг үзүүлэх, эх орондоо хамгаалалттай эдийн засгийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах, даатгалын салбарт олон улсын жишигт нийцсэн үйлчилгээг бий болгоход оршино.
- 1.5. Холбоо нь аймаг, хотод өөрийн төлөөлөлтэй байж болох бөгөөд төлөөлөл нь орон тооны бус байна.
- 1.6. Холбоог хуульд заасан үндэслэлээс бусад үндэслэлээр татан буулгахыг хориглоно.
- 1.7. **Холбооны нэр:**
  - 1.7.1. Монгол хэл дээр: Монголын Даатгалын Зуучлагчдын Холбоо /товчлол "МДЗХ" гэх/
  - 1.7.2. Англи хэл дээр: Mongolian Insurance Brokers Association /товчлол "MIBA" гэх/
- 1.8. **Үүсгэн байгуулсан огноо:** 2012 оны 10 дугаар сарын 25-ны өдөр.

- 1.9. Холбоо нь өөрийн бэлгэдэл, тамга, албан бичгийн хэвлэмэл хуудас, банкны байгууллагад харилцах данстай байна. Мөн өөрийн хэвлэл мэдээллийн байгууллагатай, веб сайттай байж болно.
- 1.10. **Холбооны хаяг:**  
Монголын Даатгалын Зуучлагчдын Холбоо  
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Юнитт центр 503 тоот  
Утас: (976) 88028528  
Электрон шуудан: info@miba.mn
- 1.11. Нэр томъёоны тайлбар:
- 1.11.1. “Бүх гишүүдийн хурал” гэж Холбоонд гишүүнчлэлтэй, саналын эрхтэй гишүүдийн хуралдааныг хэлнэ.
- 1.11.2. “Удирдах зөвлөл” гэж Бүх гишүүдийн хурлын чөлөө цагт холбооны өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүрэгтэй Бүх гишүүдийн хурлаар сонгогдсон гишүүдийг хэлнэ.
- 1.11.3. “Хороо” Холбооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор байгуулагдсан ажлын хэсгийг хэлнэ.
- 1.11.4. “Олонхын санал” гэж нийт хуралд оролцогчдын хоёрны нэгээс их буюу 50+1 хувийн саналыг хэлнэ.
- 1.11.5. “Дийлэнх олонхын санал” гэж нийт хуралд оролцогчдын гуравны хоёроос их буюу 66.6 хувийн саналыг хэлнэ.

### **Хоёр. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ**

- 2.1. Холбоо нь энэхүү дүрэмд заагдсан үндсэн зорилгоо хэрэгжүүлэхийн тулд хуулиар хориглоогүй дараах төрлийн үйл ажиллагааг эрхлэн явуулна. Үүнд:
- 2.1.1. Гишүүдийнхээ эрх ашгийг хамгаалж дуу хоолойг нийтэд хүргэх, тулгамдаж буй асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;
- 2.1.2. Төрийн захиргааны байгууллага, бусад хувийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран даатгуулагчдын эрх ашиг, сонирхлыг дээдлэн ажиллах төлөвшлийг зах зээлд бий болгох үүднээс идэвх санаачилгатай ажиллах;
- 2.1.3. Даатгалын зуучлалын талаарх эрх зүйн орчныг сайжруулах, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам боловсруулах болон өөрчлөлт оруулахад төрийн захиргааны холбогдох байгууллагуудад санал хүргүүлэх, тэдэнтэй хамтарч ажиллах;
- 2.1.4. Гишүүдийнхээ мэргэжлийн болон эдийн засгийн чадавхыг дээшлүүлэх талаар сургалт үйлчилгээ зохион байгуулах;

- 2.1.5. Даатгалын салбарт мэдлэг мэдээлэлтэй хэрэглэгчийг төлөвшүүлэх, төрийн болон хувийн аж ахуйн нэгж байгууллагууд, иргэнд мэргэжил, арга зүйн удирдлага, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, сургалт зохион байгуулах;
- 2.1.6. Гишүүн байгууллага болон даатгалын үйл ажиллагааны чиглэлээр ажиллаж буй төрийн болон хувийн аж ахуйн нэгж, байгууллагууд, даатгалын мэргэжлийн оролцогчдод даатгалын чиглэлээр сургалт, семинар зохион байгуулах;
- 2.1.7. Даатгалын үйл ажиллагааны чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил явуулах;
- 2.1.8. Хэвлэл мэдээллээр даатгалын үйл ажиллагааг нийтэд таниулах, гишүүн байгууллагуудыг сурталчлах;
- 2.1.9. Мэргэжлийн ном сэтгүүл, товхимол хэвлэн нийтлүүлэх;
- 2.1.10. Даатгалын зуучлалын чиглэлээр олон улсын нэр хүндтэй байгууллагуудтай түншлэх, гишүүнээр элсэх, хамтран ажиллах;
- 2.1.11. Даатгалын зуучлалын форумыг зохион байгуулах;
- 2.1.12. Гишүүдийн бүртгэл, мэдээлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулах;
- 2.1.13. Монгол улсын Төрийн бус байгууллагын тухай хуулиар зөвшөөрсөн бөгөөд Холбооны зорилготой нийцэж буй бусад үйл ажиллагаа эрхлэх.
- 2.2. Холбоо нь бүх гишүүддээ эрх тэгш үйлчлэх бөгөөд үйл ажиллагаандаа нийт гишүүдийн оролцоог хангаж ажиллахыг эрмэлзэнэ.
- 2.3. Холбоо ашгийн төлөө үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

### **Гурав. ХОЛБООНЫ ГИШҮҮНЧЛЭЛ**

- 3.1. Холбооны гишүүнчлэлийн байдлыг тухайн байгууллагын Холбооны үндсэн үйл ажиллагаа нь дахь оролцоо, хамтын ажиллагаа зэргээс хамааран дараах байдлаар ангилна. Үүнд:
  - 3.1.1. Үндсэн гишүүн;
  - 3.1.2. Дэмжих гишүүн.
- 3.2. Үндсэн гишүүн гэдэгт энэхүү дүрмийн 4.1-т заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх эрх бүхий Монгол Улсын нутаг дэвсгэрт даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хорооноос авсан хуулийн этгээд болон өөрийн салбараа Монгол улсад байгуулсан гадаадын даатгалын зуучлагчийг ойлгоно.

- 3.3. Дэмжих гишүүн гэдэгт энэхүү дүрмийн 4.2-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх эрхтэй, холбоонд дэмжих гишүүнээр бүртгэгдсэн даатгалын зуучлагч байгууллага болон өөрийн салбараа Монгол улсад байгуулсан гадаадын даатгалын зуучлагчийг ойлгоно.
- 3.4. Холбооны гишүүнд бүртгэгдсэн байгууллага нь гишүүнчлэлийн татварыг тогтоосон хэмжээгээр, заасан хугацаанд тухай бүр төлнө.
- 3.5. Холбооны ажлын алба нь гишүүнчлэлийн бүртгэл, мэдээллийг шинэчлэн хөтөлнө.
- 3.6. Гишүүнээр элсэхийг хүссэн этгээд нь дараах бичиг баримтыг бүрдүүлэн Холбооны ажлын албанд хүргүүлнэ. Үүнд:
  - 3.6.1. Гишүүнээр элсэх хүсэлт;
  - 3.6.2. Зохицуулах хорооноос олгогдсон Даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар;
  - 3.6.3. Байгууллагын танилцуулга.
- 3.7. Холбооны ажлын алба нь хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 7 хоногийн дотор хянан бүрдэл гүйцэд тохиолдолд Холбооны Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ. Хурал цахим байж болно.
- 3.8. Гишүүнээр элсэх өргөдлийг Холбооны Удирдах зөвлөлийн хурлаар хүсэлт гаргасан байгууллагыг төлөөлөх эрх бүхий этгээдийг байлцуулан хэлэлцэх бөгөөд Удирдах зөвлөл нь тухайн этгээдийг гишүүнээр элсүүлэхээс татгалзах болон түр хугацаагаар түдгэлзүүлэх эрх эдэлнэ.
- 3.9. Холбооны Ерөнхийлөгч нь хүсэлт гаргасан этгээдэд гишүүний гэрчилгээг гардуулан өгснөөр Холбооны гишүүн болно.
- 3.10. Шинээр элссэн гишүүний тухай мэдээллийг Холбоо өөрийн вэб хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр мэдээнэ.
- 3.11. Гишүүн нь холбоотой ижил төстэй зорилго, үйл ажиллагаа эрхлэгч даатгалын зуучлагч мэргэжлийн байгууллагуудын холбоо, эвслийн гишүүнээр элсэхдээ Холбоонд мэдэгдэнэ.
- 3.12. Холбооны дүрмийн заалтуудыг зөрчсөн Холбооны нэр хүндэд харшлах үйл ажиллагаа явуулсан, Холбооны төсвийн хөрөнгийг хувьдаа завшсан эсхүл аль нэг гишүүний хувийн ашиг сонирхлыг хангахад ашиглуулсан гишүүний асуудлыг Удирдах зөвлөлийн хурлаар авч хэлэлцэн, сануулга огч гишүүнчлэлээс түдгэлзүүлэх, улмаар хасаж болно.
- 3.13. Тухайн гишүүн өөрийн буруутай үйлдлийг ухамсарлан, гишүүн болох хүсэлтээ бичгээр гаргасан тохиолдолд Удирдах зөвлөлийн гишүүдийн хурлаар дахин авч хэлэлцэн, гишүүнчлэлийг сэргээх эсэхийг шийдвэрлэнэ.

- 3.14. Гишүүнээр элсэх сонирхолтой этгээд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
- 3.14.1. Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2-т заасан даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрөлтэй, даатгалын үйл ажиллагааны чиглэлээр мэргэшсэн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байх;
  - 3.14.2. Холбооны дүрэмтэй танилцаж үзэл баримтлал, үнэт зүйлсийг хүлээн зөвшөөрсөн байх;
  - 3.14.3. Холбооноос гаргасан Мэргэжлийн ёс зүйн дүрэм болон бусад дүрэм журамтай танилцан дагаж мөрдөхөөр зөвшөөрсөн байх.

#### Дөрөв. ГИШҮҮНИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1. Үндсэн гишүүн дараах эрхтэй. Үүнд:
- 4.1.1. Бүх гишүүдийн хуралд оролцох, санал өгөх, асуулт асуух, хариулт авах, гомдол шүүмжлэл гаргах
  - 4.1.2. Бүх гишүүдийн хуралд санал оруулах, өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх;
  - 4.1.3. Холбооны Удирдах зөвлөлд нэр дэвших, сонгох, сонгогдох;
  - 4.1.4. Холбооны үйл ажиллагааны тайлантай танилцах;
  - 4.1.5. Холбооноос даатгалын зуучлалын үйл ажиллагаатай холбоотой мэргэжлийн туслалцаа авах, сургалтанд хөнгөлөлттэй үнээр суралцах ба энэ талаар шаардлага тавих;
  - 4.1.6. Холбооны Удирдах зөвлөл болон Хороодод өөрийн эрх ашгийг хамгаалуулахаар санал хүсэлт гаргах, шаардах;
  - 4.1.7. Холбооны Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудлаар санал зөрүүтэй бол энэ тухайгаа хурлын тэмдэглэлд тусгайлан тэмдэглүүлэх;
  - 4.1.8. Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч төрийн байгууллага болон бусад байгууллагуудын өмнө өөрийн хууль ёсны ашиг сонирхол, байгууллагын нэр хүндийг Холбоогоор дамжуулан хамгаалуулах, төлөөлүүлэх;
  - 4.1.9. Холбооны үйл ажиллагаатай холбоотой байгуулагдсан хороонд харьяалагдаж, хорооны тэргүүлэгч гишүүнийг сонгох, сонгогдох;
  - 4.1.10. Холбоонд хандив тусламж өгөх, донор байгууллагатай холбож өгөх;
  - 4.1.11. Холбооны гишүүнээс гарах.

- 4.2. Дэмжих гишүүн дараах эрхтэй. Үүнд:
- 4.2.1. Бүх гишүүнийн хуралд саналын эрхгүй оролцох;
  - 4.2.2. Холбооны үйл ажиллагааны тайлантай танилцах;
  - 4.2.3. Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч төрийн байгууллага болон бусад байгууллагуудын өмнө өөрийн хууль ёсны ашиг сонирхол, байгууллагын нэр хүндийг Холбоогоор дамжуулан хамгаалуулах, төлөөлүүлэх;
  - 4.2.4. Холбоонд хандив тусламж өгөх, донор байгууллагатай холбож өгөх;
  - 4.2.5. Холбооны гишүүнээс гарах.
- 4.3. Гишүүдийн үүрэг:
- 4.3.1. Холбооны дүрэм, бодлого, шийдвэрийг сахин мөрдөж, гишүүдийн эв нэгдэл, харилцан ойлголцол, тэдгээрийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцох;
  - 4.3.2. Холбооны гишүүн нь даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийг сахин биелүүлж мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ, дүрэм, журмыг даган мөрдөх, үнэнч шударга байж, даатгалын салбарт зуучлагчийн мэргэжлийн нэр хүндийг эрхэмлэн дээдлэх;
  - 4.3.3. Холбооноос зохион байгуулж буй сургалт, арга хэмжээнд идэвхтэй оролцож, мэргэжлийн чадвар, туршлагаа байнга дээшлүүлэх;
  - 4.3.4. Холбоонд санхүүгийн талаар дэмжлэг үзүүлж, гишүүний татвар болон бусад төрлийн санхүүжилт үзүүлэхээр үүрэг хүлээсэн бол цаг хугацаанд нь шилжүүлэх;
  - 4.3.5. Гишүүнчлэлийн татвар төлөөгүй бол дүрэмд заасан эрх эдлэхгүй байх;
  - 4.3.6. Холбооны зорилго, чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Гишүүдийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг Холбоо хүссэн бол Монгол Улсын хуулиар хязгаарласнаас бусад хүрээнд, цаг тухайд нь, үнэн зөв гаргаж өгөх;
  - 4.3.7. Холбооноос зохион байгуулж буй арга хэмжээ, уулзалт, семинарт төлөөлөгчөө оролцуулах, оролцуулах боломжгүй бол энэ тухайгаа Холбоонд урьдчилан мэдэгдэж байх;
  - 4.3.8. Хэлэлцэх асуудлаар гаргасан саналын хариуг цаг хугацаанд нь бичгээр өгөх;
  - 4.3.9. Холбооны удирдлагын хууль ёсны шаардлагыг биелүүлэх, хэрэв биелүүлэх боломжгүй гэж үзвэл тайлбараа бичгээр гаргах;
  - 4.3.10. Холбооноос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх;

- 4.3.11. Даатгал, даатгалын зуучлалын талаарх олон нийтийн боловсролыг хөгжүүлэх, мэдлэг, мэдээллийг өөрийн боломжтой бүх хэлбэрээр түгээх;
- 4.3.12. Холбооны гишүүн нь холбоотой ижил төстэй зорилго, үйл ажиллагаа эрхлэгч даатгалын зуучлагч бусад мэргэжлийн байгууллагуудын холбоо, эвслийн гишүүнд элсэхгүй байх.
- 4.3.13. Хаягийн өөрчлөлт хийх тухай бүрт Холбоонд мэдэгдэж бүртгэлд өөрчлөлт хийлгэж байх.
- 4.3.14. Дүрмээр хүлээсэн үүргээ биелүүлэх;

#### **Тав. ГИШҮҮН БАЙГУУЛЛАГА НЬ ДАРААХ ЗҮЙЛСИЙГ МӨРДЛӨГӨ БОЛГОН АЖИЛЛАНА**

- 5.1. Холбооны гишүүн нь даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа, ач холбогдлыг олон нийтэд сурталчлан, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах, эх орондоо хамгаалалттай эдийн засгийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах, даатгалын салбарт олон улсын жишигт нийцсэн үйлчилгээг бий болгоход мэргэжлийн туслалцааг үзүүлэхийн төлөө ажиллана.
- 5.2. Гишүүд нь Монгол Улсын Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгож, Холбооны дүрэм болон Мэргэжлийн ёс зүйн дүрмийг хэрэгжүүлж ажиллана.
- 5.3. Холбооны гишүүнчлэл нь бусдад шилжихгүй байна.
- 5.4. Холбооны гишүүнчлэлтэй холбоотой асуудлыг энэхүү дүрмээр зохицуулна.
- 5.5. Холбооны гишүүний хууль бус үйл ажиллагааны улмаас иргэд, аж ахуйн нэгж байгууллагад учирсан хохирол, түүнээс үүссэн хариуцлагыг Холбоо хүлээхгүй.
- 5.6. Холбооны гишүүн нь Холбооны нэрийн өмнөөс гэрээ хэлцэл хийх, өөрийн эрх ашгийн үүднээс элдэв амлалт, үүрэг хүлээх, Холбооны нэрийг ашиглахыг хориглоно.

#### **Зургаа. ХОЛБООНЫ ГИШҮҮНИЙ ТАТВАР**

- 6.1. Холбооны гишүүнчлэлийн татварын хэмжээг Холбооны Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн тогтооно.
- 6.2. Холбооны бүх гишүүд гишүүнчлэлийн татвараа тухайн жилийн 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор төлж дуусгасан байх.
- 6.3. Холбооны гишүүнчлэл нь дуусгавар болсон тохиолдолд гишүүнчлэлийн татварыг буцаан олгохгүй.

## **Долоо. ГИШҮҮНИЙГ ТӨЛӨӨЛӨХ ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДИЙГ БҮРТГҮҮЛЭХ**

- 7.1. Гишүүн нь өөрийн байгууллагыг төлөөлж Холбооны хуралд оролцох, санал өгөх эрх бүхий этгээдийг томилж Холбоонд албан тоотоор мэдэгдэх үүрэгтэй.
- 7.2. Төлөөлөх эрх бүхий этгээдийг тодорхой шалтгааны улмаас өөрчилж болох бөгөөд өөрчлөгдсөн тухай бүр Холбоонд албан тоотоор мэдэгдэнэ.
- 7.3. Холбооны хуралд зөвхөн холбоонд бүртгэлтэй эрх бүхий этгээд эсхүл итгэмжлэлийн үндсэн дээр төлөөлөх эрх бүхий этгээд оролцох эрхтэй.

### **Найм. ХОЛБООНЫ НЭРИЙГ ХЭРЭГЛЭХ**

- 8.1. Холбооны гишүүн нь Холбооны зөвшөөрөлгүйгээр Холбооны нэр ашиглах, хэрэглэхийг хориглоно.
- 8.2. Холбооны нэрийг Холбооны Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч, Удирдах зөвлөлийн гишүүн, Гүйцэтгэх захирал, Ерөнхий менежер болон Холбооны ерөнхийлөгчийн итгэмжилсэн этгээд хэрэглэх эрхтэй байна.
- 8.3. Холбооны нэрийн өмнөөс аливаа хурал, цуглаанд оролцох, үйл ажиллагааг явуулсан тохиолдолд түүний талаар Холбооны Удирдах зөвлөлд тайланг ирүүлнэ.

### **Ес. ХОЛБООНЫ УДИРДЛАГА, БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

- 9.1. Холбоо нь удирдлага, зохион байгуулалтын дараах бүтэцтэй байна. Үүнд:
  - 9.1.1. Бүх гишүүдийн хурал
  - 9.1.2. Удирдах зөвлөл
  - 9.1.3. Ерөнхийлөгч
  - 9.1.4. Дэд ерөнхийлөгч
  - 9.1.5. Хороо /ажлын хэсэг
  - 9.1.6. Гүйцэтгэх захирал /Ерөнхий менежер
  - 9.1.7. Ажлын алба
- 9.2. Холбоо энэхүү дүрэмд заасан зорилго, чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор Удирдах зөвлөлийн шийдвэрийн дагуу Удирдах зөвлөлийн дэргэд Хороо эсхүл ажлын хэсгийг байгуулан ажиллуулж болно.
- 9.3. Хороодын ажиллах зорилго, чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээ, хороодын гишүүдийг сонгох, томилох асуудлыг Удирдах зөвлөлийн хурлаар шийдвэрлэж, тогтоол гаргана.
- 9.4. Холбоо нь Гүйцэтгэх захирал, Ерөнхий менежер гэсэн орон тоотой байна.
- 9.5. Холбоо нь орон тооны бус Зөвлөх, Хүндэт ерөнхийлөгчтэй байж болно.

- 9.6. Холбооны Зөвлөх нь өмнөх сонгуульт хугацаанд Ерөнхийлөгчийн ажлыг хашиж байсан этгээд байх бөгөөд шинээр томилогдсон Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаанд өөрийнх нь саналыг харгалзан Холбооны Зөвлөхөөр томилно.
- 9.7. Холбооны зөвлөх нь Удирдах зөвлөлийн хуралд оролцож болох бөгөөд саналын эрхгүй байна.
- 9.8. Холбооны зөвлөх нь Ерөнхийлөгч байх хугацаанд хийж, хэрэгжүүлж байсан ажил, бодлогын асуудлаар шинээр бүрэн эрхээ хэрэгжүүлж буй Ерөнхийлөгчид зөвлөх үүрэгтэй байна.
- 9.9. Холбооны үйл ажиллагаа, хөгжил дэвшилд үнэтэй хувь нэмэр оруулсан этгээдийг Холбооны Хүндэт ерөнхийлөгчөөр томилно.

### **Арав. БҮХ ГИШҮҮДИЙН ХУРАЛ**

- 10.1. Холбооны эрх барих дээд байгууллага нь Бүх гишүүдийн хурал байна. Бүх гишүүдийн хурал нь Үндсэн болон Дэмжигч гишүүн Гүйцэтгэх захирал эсвэл энэхүү дүрмийн 7.1-т заасан этгээдийн бүрэлдэхүүнтэй байна.
- 10.2. Бүх Гишүүдийн хурал нь жилд нэгээс доошгүй удаа, жил бүрийн 1-р улиралд хуралдана. Шаардлагатай үед ээлжит бус Бүх гишүүдийн хурлыг хуралдуулж болно.
- 10.3. Ээлжит бус Бүх гишүүдийн хурлыг саналын эрх бүхий гишүүдийн 50+1 хувь нь хуралдах санал гаргасан тохиолдолд Холбооны Ерөнхийлөгч зарлан хуралдуулна.
- 10.4. Холбооны ээлжит Бүх Гишүүдийн хурлын товыг ажлын 10-аас доошгүй өдрийн өмнө зарлана.
- 10.5. Холбооны ээлжит бус Бүх гишүүдийн хурлыг ажлын 5-аас доошгүй өдрийн өмнө зарлана.
- 10.6. Ээлжит Бүх гишүүдийн хурал зарласан өдрөөс ажлын 7 өдрийн дотор, ээлжит бус Бүх гишүүдийн хурал зарлагдсан өдрөөс ажлын 2 өдрийн дотор хэлэлцэх асуудлыг гишүүдэд хүргүүлж санал авна.

### **Арван нэг. БҮХ ГИШҮҮДИЙН ХУРЛЫН БҮРЭН ЭРХ**

- 11.1. Дараах асуудлыг зөвхөн Бүх Гишүүдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ. Үүнд:
  - 11.1.1 Холбооны дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу түүний шинэчлэн найруулгыг батлах;
  - 11.1.2 Холбооны үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай дүрэм, журмыг батлах, нэмэлт өөрчлөлт оруулах;

- 11.1.3 Холбооны Ерөнхийлөгч, Удирдах зөвлөлийн гишүүдийг нууц санал хураалтаар сонгох, түүний бүрэн эрхийн хугацаа дууссанаар эсхүл бүрэн эрхийн хугацаа нь дуусахаас өмнө өөрөө чөлөөлөгдөх хүсэлт гаргасан тохиолдолд түүнийг албан үүргээс чөлөөлөх, эрх хэмжээг нь дуусгавар болгох;
- 11.1.4 Холбооны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэх;
- 11.1.5 Холбоог өөрчлөн байгуулах, татан буулгах, татан буулгах комиссыг томилох;
- 11.1.6 Холбооны гишүүдийн татварын хэмжээг тогтоох;
- 11.1.7 Удирдах зөвлөлийн шийдвэрээр хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал.

#### **Арван хоёр. БҮХ ГИШҮҮДИЙН ХУРЛЫН ИРЦ, САНАЛ**

- 12.1. Хурал нь нийт үндсэн гишүүдийн 50+1 хувийн ирцтэйгээр хүчин төгөлдөр болно.
- 12.2. Хуралд үндсэн гишүүн байгууллага бүр нэг саналын эрхтэй оролцоно.
- 12.3. Хурлаар хэлэлцсэн асуудал тус бүрийг саналын эрхтэй оролцогчдын олонхын саналаар шийдвэрлэнэ.
- 12.4. Хуралд оролцогч үндсэн гишүүн нь тогтоосон гишүүний татварын өртэй нөхцөлд Бүх Гишүүдийн хурлаар хэлэлцэх асуудалд саналын эрхтэй байх хэдий ч Удирдах зөвлөлийн гишүүн болон бусад албан тушаалд нэр дэвших эрхийг эдлэхгүй.
- 12.5. Даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрөлтэй бүх хуулийн этгээд Холбооны хамтран ажиллагч байна.
- 12.6. Холбооны бүх гишүүдийн хуралд дэмжигч гишүүн, хамтран ажиллагч байгууллагууд оролцох эрхтэй бөгөөд санал өгөх, асуудал дэвшүүлэх, хүсэлт гаргах эрх эдлэхгүй.

#### **Арван гурав. БҮХ ГИШҮҮДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР, ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

- 13.1. Бүх Гишүүдийн хурлын шийдвэр нь "Тогтоол" байна. Дүрэмд заасан асуудлыг хуралд оролцож буй саналын эрхтэй оролцогчдын олонхын саналаар батална.
- 13.2. Холбооны Гүйцэтгэх захирал /Ерөнхий менежер хурлын тэмдэглэл хөтлөх ба тэмдэглэлд Ерөнхийлөгч болон хуралд оролцогсад гарын үсэг зурж баталгаажуулна.

- 13.3. Хурлын шийдвэрт хуралд оролцсон саналын эрхтэй гишүүд гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд аль нэг гишүүний гарын үсэг зураагүй нь шийдвэрийн хүчин төгөлдөр байдалд нөлөөлөхгүй.

#### Арван дөрөв. ХОЛБООНЫ УДИРДАХ ЗӨВЛӨЛ

- 14.1. Холбооны Бүх гишүүдийн хурлын чөлөөт цагт Холбооны эрх барих байгууллага нь Удирдах зөвлөл байна.
- 14.2. Холбооны Удирдах зөвлөл нь Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч, гурван Хорооны тэргүүн гэсэн нийт үндсэн 5 /таван/ гишүүнтэй байна.
- 14.3. Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд гишүүдийн 50+1 хувь оролцсоноор хурлын ирц бүрдэнэ.
- 14.4. Удирдах зөвлөлийн хурал нь ээлжит болон ээлжит бус гэсэн хэлбэртэй байх бөгөөд хурлыг Ерөнхийлөгч зарлана. Ерөнхийлөгчийг эзгүйд Дэд Ерөнхийлөгч/түүний томилсон Удирдах зөвлөлийн гишүүн зарлаж хуралдуулна. Ээлжит хурлыг улирал бүрийн эхний сарын хоёрдугаар долоо хоногт багтаан хуралдуулна.
- 14.5. Удирдах зөвлөлийн ээлжит бус хурлыг Ерөнхийлөгчийн санаачилгаар эсхүл Удирдах зөвлөлийн гишүүдийн 50+1 хувь нь хуралдах санал гарснаар хуралдуулна.
- 14.6. Удирдах зөвлөлийн гишүүдийн 50+1 хувь оролцсон хурал хүчинтэй болж хуралд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэр гаргана. Санал тэнцсэн тохиолдолд Ерөнхийлөгчийн саналыг үндэслэн шийдвэрлэнэ.
- 14.7. Хурлыг танхимаар биечилж хийх ба шаардлагатай тохиолдолд цахим хэлбэрээр хийж болно.
- 14.8. Холбооны Ерөнхийлөгч болон Удирдах зөвлөл нь хоёр хүртэлх жилийн хугацаатай томилогдоно.
- 14.9. Удирдах зөвлөлийн гишүүн нь Холбооны албан тушаалын нэр хүндийг ашиглаж бусдад давуу байдал олгосон, эв нэгдлийг бусниулсан, хөгжлийн хамтын ажиллагаанд саад учруулсан, Холбооны дүрмийн заалтуудыг зөрчсөн, Холбооны нэр хүндэд харшлах үйл ажиллагаа явуулсан, Холбооны төсвийн хөрөнгийг хувьдаа завшсан эсхүл аль нэг гишүүний хувийн ашиг сонирхлыг хангахад ашиглуулсан болох нь тогтоогдсон тохиолдолд Удирдах зөвлөлийн хурлаар авч хэлэлцэн, ээлжит бус Бүх гишүүдийн хурлыг зарлан хуралдуулж, Удирдах зөвлөлийн гишүүнээс хасаж хариуцлага тооцно.

- 14.10. Энэ дүрмийн 14.9-д зааснаар Удирдах зөвлөлийн гишүүнээс хасагдсан этгээдийн Холбооны гишүүнчлэлийн эрхийг дүрмийн 3.12-т заасны дагуу шийдвэрлэнэ.
- 14.11. Удирдах зөвлөлийн хурлаас тогтоол гарах бөгөөд түүнд Ерөнхийлөгч гарын үсэг зурж баталгаажуулна.
- 14.12. Удирдах зөвлөлийн шийдвэрээр байнгын болон түр хороог үүсгэн байгуулж болно.

#### **Арван тав. УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭН ЭРХ**

- 15.1. Удирдах зөвлөл нь дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэнэ. Үүнд:
- 15.1.1. Холбооны үйл ажиллагааны үндсэн чиглэл, стратегийг тогтоох;
- 15.1.2. Холбоо, түүний ажлын албаны жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг батлах;
- 15.1.3. Төсөв, төлөвлөгөө, үүрэгт ажлуудын биелэлтэд үнэлгээ өгөх;
- 15.1.4. Холбооны ажлын албаны бүтэц, орон тоо, зохион байгуулалтыг тухайн жилийн төсөв, төлөвлөгөөний хамт хэлэлцэн батлах;
- 15.1.5. Холбооны ээлжит болон ээлжит бус Бүх Гишүүдийн хурлыг зарлан хуралдуулах, санал хураалт явуулах шийдвэр гаргах;
- 15.1.6. Холбооны Бүх Гишүүдийн хурлаар хэлэлцэх асуудал, хурал хуралдуулахтай холбогдох бусад асуудлыг шийдвэрлэх;
- 15.1.7. Холбооны Дэд Ерөнхийлөгчийг Удирдах зөвлөлийн гишүүд дундаасаа нууцаар санал хурааж сонгох, огцруулах;
- 15.1.8. Холбооны үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор ажлын алба болон хороог байгуулах;
- 15.1.9. Холбооны бүтэц, зохион байгуулалт болон түүний үйл ажиллагааг зохицуулсан журам батлах;
- 15.1.10. Шинээр гишүүн элсүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэх;
- 15.1.11. Холбооны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлт болон цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулж, Холбооны Бүх Гишүүдийн хуралд танилцуулах;
- 15.1.12. Холбооны Гүйцэтгэх захирал, Ерөнхий менежерийг сонгох, томилох, өөрчлөх, чөлөөлөх, тэдгээрийн тайланг хэлэлцэх, түүний бүрэн эрхийн хугацааг тогтоох

- 15.1.13. Холбооны гишүүдийн нийтлэг эрх ашгийг хөндсөн асуудлыг хэлэлцэж, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх;
- 15.1.14. Гишүүдээс гаргасан санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх;
- 15.1.15. Холбоонд гишүүн элсүүлэх, хасах;
- 15.1.16. Гишүүн байгууллагын захиалгын дагуу даатгал, даатгалын зуучлалын мэргэжилтнийг бэлтгэх, тэдний мэргэжил, дадлагыг дээшлүүлэх, ажиллах хүчнийг зохицуулах асуудлыг зохих байгууллагуудтай хамтран шийдвэрлэж, удирдах ажилтан, мэргэжлийн хүмүүсийг гадаад дотоодын сургалтанд хамруулах, туршлага судлуулах, дадлага олгох ажлыг зохион байгуулах;
- 15.1.17. Холбооны гишүүн байгууллагуудыг гадаадын ижил төстэй болон сонирхогч байгууллагуудтай холбоо тогтоох, гэрээ хэлэлцээр байгуулахад нь зуучлах, тэднийг төлөөлөн гэрээ хэлцэл байгуулах;
- 15.1.18. Ажлын өндөр амжилт бүтээл гаргасан Удирдах зөвлөлийн гишүүн, гишүүн байгууллага, хувь хүнийг төр, засгийн болон Холбооны шагнал урамшуулал, цол хэргэмд хамруулах арга хэмжээ авах;
- 15.1.19. Холбогдох эрх бүхий байгууллагуудын албан тушаалд Холбооны эрх ашгийг төлөөлүүлэхээр тохиромжтой этгээдийг нэр дэвшүүлэх;
- 15.1.20. Их дүнтэй хэлцэл буюу Холбооны нийт хөрөнгийн 50 хувиас дээш дүнтэй хэлцлүүдийг шийдвэрлэх.
- 15.1.21. Холбооны үйл ажиллагаа, цар хүрээг тэлэх, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор төрийн болон хувийн байгууллага, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээ, харилцан ойлголцлын санамж бичиг байгуулах.

**Арван зургаа. УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНИЙ ЭРХ ҮҮРЭГ,  
ХАРИУЦЛАГА**

- 16.1. Удирдах зөвлөлийн гишүүн нь сүүлийн 12 сарын хугацаанд Холбооны үндсэн гишүүнчлэлтэй байгууллагын Захирал, эсхүл удирдах албан тушаалтан байх бөгөөд хууль эрх зүйн аливаа зөрчил гаргаагүй этгээд байна.
- 16.2. Удирдах зөвлөлийн гишүүнийг Холбооноос зохион байгуулж буй аливаа үйл ажиллагаанд хөнгөлөлттэй үнээр оролцуулах.
- 16.3. Удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллахаар сонгогдсон Гишүүний ажиллах хугацааны гишүүнчлэлийн татварын 50 хүртэлх хувийг Ерөнхийлөгчийн шийдвэрээр чөлөөлж болно.

- 16.4. Удирдах зөвлөлийн гишүүн нь Монгол улсын эсхүл гадаадын иргэн байж болно.
- 16.5. Холбооны удирдах зөвлөлийн гишүүн нь дараах бүрэн эрхийг эдэлнэ. Үүнд:
- 16.5.1. Удирдах зөвлөлийн хурлаар тодорхой асуудал хэлэлцүүлэхээр оруулах;
- 16.5.2. Асуудал хэлэлцэн шийдвэрлэхэд санал өгөх;
- 16.5.3. Хэлэлцэж байгаа асуудлын талаар асуулт асуух, хариулт авах, санал дүгнэлт гаргах;
- 16.5.4. Холбооны сонгуульт албан тушаалд сонгогдох, тэдгээрт өөрийн нэрийг дэвшүүлэх;
- 16.5.5. Холбооны удирдах зөвлөлийн дэргэдэх аль нэг хорооны гишүүн байх;
- 16.5.6. Холбооны удирдах зөвлөлөөс томилогдсон этгээдийн илтгэл тайлан хэлэлцэх, тэдэнд үл итгэхээ илэрхийлж эргүүлэн татах, огцруулах санал оруулах.
- 16.6. Холбооны удирдах зөвлөлийн гишүүн нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:
- 16.6.1. Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмыг сахин биелүүлэх;
- 16.6.2. Үйл ажиллагаандаа гишүүдийн нийтлэг ашиг сонирхлыг нэн тэргүүнд хамгаалах;
- 16.6.3. Удирдах зөвлөлийн хуралдаанд тогтмол оролцож, олонхын саналаар шийдвэрлэгдсэн асуудлыг хүндэтгэж, хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцох;
- 16.6.4. Удирдах зөвлөлийн гишүүний хувьд үг хэлэх, санал гаргах, дүгнэлт хийхдээ асуудалд нотолгоотой, хариуцлагатай байж, Холбооны үндсэн зорилгыг дээдлэн хэрэгжүүлэхэд санаачилгатай хандах;
- 16.6.5. Удирдах зөвлөлийн гишүүд нь холбооны бодлогын залгамж чанар, нэгдмэл байдлыг хангахыг эрхэмлэн ажиллах;
- 16.6.6. Хамтрагч гишүүнээс өөрийн эрх ашгийг хамгаалуулах, бодлогын дэмжлэг авахаар гаргасан хүсэлтийг хэлэлцэн шийдвэрлэх.
- 16.7. Удирдах зөвлөл нь үйл ажиллагаагаа хөнгөвчлөх, гишүүдийн оролцоог сайжруулах зорилго бүхий байнгын болон түр хороодыг байгуулж болно.
- 16.8. Хорооны дарга Удирдах Зөвлөлийн гишүүн байна.
- 16.9. Холбооны удирдах зөвлөлийн гишүүний хариуцлага
- 16.9.1. Удирдах зөвлөлийн гишүүний хууль бус үйл ажиллагааны улмаас иргэд, аж ахуйн нэгж байгууллагад учирсан хохирол, түүнээс үүссэн хариуцлагыг Холбоо хүлээхгүй.

- 16.9.2. Удирдах зөвлөлийн гишүүн нь үүргээ гүйцэтгэх явцад гаргасан эд материалын болон мөнгөн хөрөнгийн зардлын нөхөн төлбөрөөс бусад цалин, тэтгэлэг авах эрхгүй.
- 16.9.3. Гишүүний сонгуульт хугацаанд удирдах зөвлөлийн ээлжит болон ээлжит бус хурлын ирц 50 хувиас бага байсан тохиолдолд дараагийн сонгуульд нэр дэвших эрхгүй байна.
- 16.9.4. Гишүүн нь сонгуульт хугацаа дуусахаас өмнө гишүүний үүрэгт ажлаа хүлээлгэн өгөх тохиолдолд хүсэлтээ Ерөнхийлөгчид гаргах бөгөөд Гишүүнийг Бүх гишүүдийн хурлаар чөлөөлж, дараагийн гишүүнийг томилно.

#### Арван долоо. ХОЛБООНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ

- 17.1. Ерөнхийлөгч нь 1-ээс доошгүй жилийн хугацаанд Удирдах зөвлөлийн гишүүнээр ажилласан байна.
- 17.2. Ерөнхийлөгч нь хүндэтгэн үзэх шалтгаанаар эзгүй байх тохиолдолд Холбооны Дэд ерөнхийлөгч түний үүргийг түр орлон гүйцэтгэнэ.
- 17.3. Ерөнхийлөгч нь өөрийн бүрэн эрхийн хугацаанд Холбоог төлөөлөх боломжгүй болсон тохиолдолд энэхүү дүрмийн 24.2-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэнэ.
- 17.4. Ерөнхийлөгч нь дараах эрхтэй байна. Үүнд:
- 17.4.1. Холбооны Ерөнхийлөгч нь Удирдах зөвлөлийн дарга байх бөгөөд 2 жилийн хугацаатай сонгогдоно. Холбооны ерөнхийлөгч нь нэг удаа улиран сонгогдож болно.
- 17.4.2. Удирдах зөвлөлийн гишүүнд татварын хөнгөлөлт үзүүлэх шийдвэрийг гаргах;
- 17.5. Ерөнхийлөгч нь дараах үүрэг хүлээнэ. Үүнд:
- 17.5.1. Ерөнхийлөгч нь Удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, хяналт тавих, Холбооны Бүх Гишүүдийн хуралд ажлаа тайлагнах.
- 17.5.2. Ерөнхийлөгч нь холбооны гишүүнчлэлийн батламжийг хянаж, гарын үсэг зурж, холбооны тамга дарна.
- 17.5.3. Ерөнхийлөгч нь Холбооны гишүүдийн эрх ашгийг хөндсөн аливаа асуудлыг шийдвэрлэх, мэргэжлийн үйл ажиллагаа явуулахтай холбоотойгоор холбогдох байгууллага, албан тушаалтанд санал хүргүүлэхдээ уг асуудлыг Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж олонхын саналаар баталсан байна.

- 17.5.4. Ерөнхийлөгч нь холбооны зорилго, гишүүдийн нийтлэг эрх, ашиг сонирхлыг хамгаалах асуудлаар төр, засгийн байгууллага болон бусад эрх бүхий байгууллагад Холбооны байр суурийг илэрхийлэн Холбоог төлөөлж ажиллана.
- 17.5.5. Бүх гишүүдийн хурлаар дэмжигдсэн төсөв, төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавих, гүйцэтгэлийг Удирдах зөвлөл, цаашлаад Бүх гишүүдийн хуралд тайлагнана.
- 17.5.6. Удирдах зөвлөлийн хурлын санал тэнцсэн тохиолдолд саналыг эцэслэн шийдвэрлэх.
- 17.5.7. Ерөнхийлөгч нь гишүүн байгууллага, хувь хүний эрх ашиг, нэр төрийг гутаан доромжилсон, хууль зүйн үндэслэлгүйгээр гүтгэсэн, хууль бус элдэв халдлагыг таслан зогсоох арга хэмжээ авна.

#### **Арван найм. ХОЛБООНЫ ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ**

- 18.1. Дэд ерөнхийлөгч нь Удирдах зөвлөлийн гишүүн байх бөгөөд Удирдах зөвлөлийн гишүүдээс нэр дэвшүүлсний дагуу удирдах зөвлөлийн гишүүдийн олонхын саналаар Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаагаар сонгогдоно. Холбооны Дэд ерөнхийлөгч нь Ерөнхийлөгчийн эзгүйд түүнийг орлох үүрэгтэй.
- 18.2. Дэд ерөнхийлөгч нь Ерөнхийлөгч үүрэгт ажлаа түр болон бүрмөсөн гүйцэтгэж чадахгүйд хүрсэн нөхцөлд Ерөнхийлөгчийг үүрэгт ажлаа үргэлжлүүлэх хүртэл, дараагийн Бүх гишүүдийн хурлаар шинээр Ерөнхийлөгч сонгогдох хүртэл Холбооны Ерөнхийлөгчийн үүргийг орон гүйцэтгэнэ.
- 18.3. Дэд ерөнхийлөгч нь дараагийн Ерөнхийлөгчийг сонгох сонгуульд нэр дэвших эрхтэй.

#### **Арван ес. ХОЛБООНЫ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ**

- 19.1. Гүйцэтгэх захирлыг Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаагаар Удирдах зөвлөлөөс томилно.
- 19.2. Гүйцэтгэх захирал нь Бүх гишүүдийн хурал, Удирдах зөвлөлийн хурлын цагт “Ерөнхий нарийн бичгийн дарга”-ын албан тушаалын үүргийг гүйцэтгэх бөгөөд бусад цагт “Гүйцэтгэх захирал”-ын албан тушаалын нэрээр ажил үүргээ хэрэгжүүлж, Холбоог төлөөлж ажиллана.
- 19.3. Гүйцэтгэх захирал нь Ерөнхийлөгчтэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд Холбооны өдөр тутмын үйл ажиллагааг удирдлагаар хангаж ажиллана.
- 19.4. Гүйцэтгэх захирал нь удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, Холбоог төлөөлөх зэргээр Холбооны нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.

- 19.5. Холбооны өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлын албаны бүтэц, орон тоог өөрчлөх талаар Удирдах зөвлөлийн хуралд санал оруулж, шийдвэрлүүлнэ.
- 19.6. Гүйцэтгэх захирлын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагын хэмжээ хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, хөлс урамшуулал зэрэг асуудлыг гэрээгээр зохицуулна.
- 19.7. Гүйцэтгэх захирал нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 19.7.1. Гүйцэтгэх захирал нь холбооны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах бөгөөд Төрийн бус байгууллагын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.
- 19.7.2. Бүх гишүүдийн хурал, Удирдах зөвлөлийн хурлын шийдвэр, Дүрмийн биелэлтийг хангуулж ажиллана.
- 19.7.3. Үйл ажиллагаандаа Холбооны болон гишүүдийн эрх ашгийг дээдэлж, хууль болон дүрэм, гэрээнд заасан үүргээ чандлан хэрэгжүүлэх;
- 19.7.4. Гишүүдийн бүртгэл, судалгаа, холбогдох мэдээ тайланг нэгтгэн гаргах ажлыг удирдан зохион байгуулах;
- 19.7.5. Удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээ болон гэрээгээр олгосон эрхийн хүрээнд Холбооны өмч хөрөнгө, мөнгөн хөрөнгийг захиран зарцуулах;
- 19.7.6. Холбооны үйл ажиллагааны явцын талаар Ерөнхийлөгчид тогтмол танилцуулах, өгсөн чиглэлийн дагуу ажиллах;
- 19.7.7. Шийдвэр гаргахдаа сонирхлын зөрчлөөс зайлсхийх, сонирхлын зөрчил үүсэхээр бол энэ тухай Ерөнхийлөгчид мэдэгдэх;
- 19.7.8. Хууль тогтоомж болон Удирдах зөвлөлөөс олгосон бусад бүрэн эрх.
- 19.7.9. Холбооны аж ахуй, санхүүгийн тайлан тэнцлийг хугацаанд нь гаргаж, холбогдох мэдээ, тайланг удирдлага хяналтын байгууллагад хүргэж байх;
- 19.7.10. Холбооны гишүүдээс ирсэн санал, хүсэлтийг хүлээн авч Ерөнхийлөгч болон Удирдах зөвлөлд танилцуулах.

#### **Хорь. ХОРООНЫ ДАРГА**

- 20.1. Хорооны дарга нь Удирдах Зөвлөлийн гишүүн байх бөгөөд Удирдах Зөвлөлөөс томилсон чиг үүргийн дагуу "Хороо"-г даргалж ажиллана.
- 20.2. Хорооны дарга нь хороог төлөөлөн Удирдах Зөвлөлд ажлын төлөвлөгөө, явц, хэрэгжилт, гүйцэтгэлийг танилцуулна.

- 20.3. Хорооны дарга нь Удирдах зөвлөлийн төдийгүй Холбооны гишүүний бүхий л эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.

### **Хорин нэг. ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТ, ТАЙЛАН**

- 21.1. Холбооны хөрөнгөд түүний өмчлөлд хамаарах үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгө хамаарна.
- 21.2. Холбооны орлого нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:
- 21.2.1 Гишүүдийн татвар;
- 21.2.2 Гишүүдийн хандив;
- 21.2.3 Байгууллага, иргэдийн сайн дурын хандив, тусламжийн орлого / хандив нь биет болон биет бус байна/
- 21.2.4 Холбооны зорилгыг хэрэгжүүлэхтэй холбогдсон аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлого;
- 21.2.5 Холбооны үйл ажиллагааг бэхжүүлэх болон даатгалын зуучлагчийн үйл ажиллагааг хөгжүүлэхтэй холбогдсон төсөл хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас, эсхүл Олон улсын байгууллагаас олгосон хөрөнгө.
- 21.2.6 Хуулиар зөвшөөрсөн бусад эх үүсвэр.
- 21.3. Холбооны санхүүжилтийн эх үүсвэрийг зөвхөн Бүх Гишүүдийн хурлаар батална.
- 21.4. Холбоо нь орлогоо зөвхөн дүрэмд заасан зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зарцуулна.
- 21.5. Холбооны мөнгөн хөрөнгийг удирдах зөвлөлөөс батлагдсан төсвийн дагуу зарцуулах үүргийг Ерөнхийлөгч, холбооны удирдах зөвлөл шат дараалан хариуцна.
- 21.6. Холбоо нь Монгол Улсын арилжааны банканд өөрийн төгрөгийн болон валютын харилцах данстай байна.
- 21.7. Холбоо нь Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.

### **Хорин хоёр. ХОЛБООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХОРИГЛОХ ЗҮЙЛС, ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА**

- 22.1 Холбоо нь дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Үүнд:

- 22.1.1 Холбооны орлогоос ноогдол ашиг хуваарилах, иргэн, аж, ахуйн нэгж байгууллагад хөрөнгийн баталгаа гаргахыг хориглоно.
- 22.1.2 Холбооны Удирдах зөвлөлийн гишүүн болон орон тооны албан тушаалтнуудаас Холбооны эд хөрөнгөөр хувийн ашиг олох зорилгоор санхүүгийн болон аж ахуйн үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
- 22.1.3 Холбоо нь Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, аймаг, хот орон нутгийн Иргэдийн Төлөгчдийн Хурлын сонгууль, нам, эвслийн нэр дэвшигчдэд хөрөнгө, хандив өгөхийг хориглоно.
- 22.1.4 Монгол Улсын хууль тогтоомж, Дүрмийн зорилгод харшилсан бусад үйл ажиллагаа.
- 22.2 Гишүүд, Холбооны удирдлага нь Дүрэмд заасан эрх, үүргээ зөрчсөн, хууль бус үйл ажиллагааны улмаас иргэн, аж ахуй нэгж байгууллагад учирсан хохирлыг Холбоо хариуцахгүй бөгөөд буруутай этгээд үүссэн үр дагаврыг бүрэн хариуцна.

#### **Хорин гурав. МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙ**

- 23.1 Холбоо нь Холбооны Удирдах зөвлөлийн гишүүд болон нийт гишүүдийн дагаж мөрдөх ёс зүйн дүрэмтэй байна.
- 23.2 Холбооны ёс зүйн дүрмийг удирдах зөвлөл санал оруулж бүх гишүүдийн хурлаар батална.
- 23.3 Ёс зүйн дүрмийн нэмэлт, өөрчлөлт болон шинэчлэн найруулгыг бүх гишүүдийн хурлаар батална.

#### **Хорин дөрөв. ХОЛБООГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ**

- 24.1 Нийт гишүүдийн дийлэнх олонх Холбоог татан буулгах, эсхүл өөрчлөн байгуулах санал гаргасан тохиолдолд Холбоог өөрчлөн байгуулах буюу татан буулгах асуудлыг гагцхүү Холбооны Бүх Гишүүдийн хурлаар шийдвэрлэнэ.
- 24.2 Холбоог татан буулгах шийдвэр гаргасан тохиолдолд татан буулгах комисс байгуулах бөгөөд түүний бүрэлдэхүүнд Удирдах зөвлөлийн дарга, Гүйцэтгэх захирал болон Удирдах зөвлөлийн аливаа нэг гишүүн багтаж, хуульд заасны дагуу татан буулгана.
- 24.3 Татан буулгах комисс нь дараах үүрэг гүйцэтгэнэ. Үүнд:
- 24.3.1 Холбооны эд хөрөнгийг тооллого хийж, битүүмжлэх;
- 24.3.2 Холбооны үйл ажиллагаатай холбогдсон өр авлагыг хуульд заасны дагуу барагдуулах;

- 24.3.3 Холбооны гүйцэтгэх ажилтнуудын нийгмийн баталгааг хангах арга хэмжээ авах;
- 24.3.4 Холбооны тайлан тэнцлийг гаргаж, улсын бүртгэл хяналтын байгууллагад тушаах;
- 24.3.5 Холбооны үлдэгдэл хөрөнгийг адил зорилго бүхий байгууллагад шилжүүлэх, холбооны зорилгод нийцсэн үйл ажиллагаанд зарцуулах.
- 24.4 Татан буулгах комисс нь татан буулгах үйл ажиллагааг эхлүүлж, удирдах бөгөөд энэхүү үйл ажиллагаанд туслалцаа шаардлагатай гэж үзвэл гаднын мэргэжлийн зөвлөхийг авч ажиллуулна.
- 24.5 Холбоог татан буулгасны дараа түүний төлөх бүх өр төлбөрийг барагдуулсны дараагаар үлдсэн хөрөнгийг нь Холбоотой ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагад шилжүүлнэ. Хэрэв тийм байгууллага байхгүй бол холбооны зорилготой нийцэхүйц олон нийтийн эрх ашгийг төлөөлөх үйл ажиллагаанд зориулна.
- 24.6 Бүх гишүүдийн хурлын шийдвэрээр дүрмийг шинэчлэн баталж, улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.

#### **Хорин тав. ДҮРЭМД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ**

- 25.1 Холбооны Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах асуудлыг Холбооны Бүх Гишүүдийн хуралд оролцож буй гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.

#### **Хорин зургаа. ДҮРЭМ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ**

- 26.1 Холбооны дүрмийг Бүх Гишүүдийн хурлаар баталснаар хүчин төгөлдөр болно.
- 26.2 Хүчин төгөлдөр болсон дүрмийг хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгүүлнэ.
- 26.3 Дүрмийг гурван хувь үйлдэж Холбоо, Хуулийн этгээдийн бүртгэлийн газар, Санхүүгийн Зохицуулах Хороонд тус бүр нэг нэг хувийг хадгалуулна.

Монголын даатгалын зуучлагчдын холбооны

ЕРӨНХИЙЛӨГЧ



Д.Отгонбаяр